



МОНГОЛБАНК
САНХУУГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА



The Asia Foundation

Hanns Seidel Stiftung

“МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА: ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

ЗОРИЛГО

Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэхдээ тулгамдаж буй асуудлийг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, олон улсын сайн туршлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг хуульч, эрдэмтэн, судлаачдын хүрээнд хэлэлцүүлж, харилцан мэдээлэл, туршлага солилцох, нийтийн хүртээл болгоход оршино.

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Улсын еренхий прокурорын газар

ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний зөвлөл
- Хууль зүй, дотоод хэргийн яам
- Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба
- Азийн сан
- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ханс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар

ОРОЛЦОГЧДЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Шүүх, прокурорын байгууллага, ёмгөөлөл, хууль сахиулах болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий бусад байгууллага, дотоод, гадаадын их сургуулийн эрдэмтэн, профессор багш, судлаачид, салбарын мэргэжилтнүүд илтгэл ирүүлж оролцох боломжтой.

ИЛТГЭЛИЙН СЭДВИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

1. Мөнгө угаах гэмт хэргийн төлөв байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам;
2. Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгаж, хянан шийдвэрлэхдээ тулгамдаж буй асуудал;
3. Мөнгө угаах гэмт хэргийн субъект, түүний онцлог;
4. Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг буцаах талаарх олон улсын туршлага;
5. Мөнгө угаах гэмт хэргийг шалган, шийдвэрлэж буй гадаад улсын туршлага, хууль хэрэглээний практик;
6. Үндэстэн дамнан үйлдэгдэж буй мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгаж, шийдвэрлэхдээ бус нутгийн хамтын ажиллагааны арга зам, шинэлэг арга барил;
7. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрдээлийн үнэлгээ, түүний зорилго, ач холбогдол, үнэлгээнд нийцүүлэн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа
8. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэх, хянах тогтолцооны талаарх олон улсын туршлага;
9. Санхүүгийн мэдээллийн бүтэц, тогтолцоо, үйл ажиллагааны талаар бусад орны туршлага болон сэжигтэй гүйлгээг илрүүлэхдээ тулгамдсан асуудал;
10. Эрдэлтэй гэж үнэлэгдсэн мөнгө угаах нарийн төвөгтэй арга хэлбэр буюу гуравдагч этгээдээр дамжуулан мөнгө угаах үйлдлийг мөрдөн шалгах ажиллагааны талаарх олон улсын туршлага;
11. Битүүмжлэх, хураах болон гадаад улсаас буцаан авах, буцаан олгох хөрөнгө, орлогын удирдлагын менежментийг боловсронгуй болгох арга зам;
12. Мэдээлэх үүрэгтэй этгээдээс санхүүгийн мэдээллийг хүлээн авах, түүнд дун шинжилгээ хийх, гарсан үр дүнг хууль сахиулах байгууллагуудтай солилцох чиглэлээр хамтран ажиллах тогтолцоог боловсронгуй болгох арга зам;
13. Олон улсын болон гадны хөрөнгө оруулалтай байгууллагууд, санхүүгийн эх үүсвэр нь тодорхойгүй сангудаар дамжих буй хууль бус орлогыг илрүүлэх арга зам, олон улсын туршлага;
14. Хурлын сэдэвтэй холбоотой бусад асуудал.

ИЛТГЭЛ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА

Илтгэлийг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Улсын еренхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн gpo_tri@prosecutor.mn цахим хаягаар хүлээн авна.

ИЛТГЭЛИЙГ ШАЛГАРУУЛЖ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

Улсын еренхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн, их сургуулийн эрдэмтэн, судлаач, хамтран зохион байгуулагч байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг тодорхой шалгуурыг үндэслэн шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан илтгэлүүдийг эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлнэ.

-Шаардлага хангасан илтгэлүүдийг эмхэтгэн хэвлүүлж, нийтийн хүртээл болгоно.

ИЛТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Илтгэлийг дангаар эсхүл бусадтай хамтран бэлтгэж болно;
- Монгол хэл эсхүл англи хэлээр бэлтгэн ирүүлнэ;
- Илтгэгчийн эрдмийн зэрэг, цол, албан тушаал, илтгэлийн сэдэв, хураангуйг монгол, англи хэлээр бэлтгэн, 4x6 хэмжээтэй зургийн (jpg) хамт ирүүлнэ;
- Цаасны хэмжээ A4;
- Хуудасны тоо 6-8 нүүр;
- Текст нь тал бүрээс 2.5 см, мөр хоорондын зай 1.15, "arial" фонтоор, үсгийн өндер 12-оор (MS word) бичигдсэн байна.

ХОЛБОО БАРИХ, МЭДЭЭЛЭЛ АВАХ УТАС, ХАЯГ:

9999-0368, 8088-0199, 9977-4281

WWW.PROSECUTOR.MN : GPO_TRI@PROSECUTOR.MN